



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бар
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

**АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАЛАНТАЙН
ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА**

2020-09-03 № ЦАА-2020/06-НА-51
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Далантайн Эрдэнэцэцэгийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигч Д.Эрдэнэцэцэг нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050" холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020761


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Д.Эрдэнэцэцэгийн Алтанбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Д.Эрдэнэцэцэгийн мөрийн хөтөлбөр /..... хуудас/-ийг хавсаргав.


Хувийг: Алтанбулаг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН 2020 ОНЫ ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАЛАНТАЙН ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР



Уриа: ТӨРСӨН НУТГАА ХӨГЖҮҮЛЖ ТҮМЭН ОЛОНДОО ТҮҮЧЭЭЛБЕ.


Нэг: Сум орон нутгийн хөгжлийн төлөө иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд сумын иргэдийн саналыг тусган хэрэгжилтэд хяналт тавьж чанар стандартыг хангуулсан ажлуудыг гүйцэтгүүлнэ.

- 1.1. “Орон нутгийн хөгжлийн сан”-г журмын дагуу иргэд, олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана.
- 1.2. Иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, иргэдийн оролцооны зохистой хэлбэрүүдийг дэмжин хамтэрч ажиллана.
- 1.3. Сумын “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг сайжруулж, иргэдийн санал хүсэлтийг хуулийн дагуу түргэн, шуурхай шийдвэрлэх ажлыг эрчимжүүлнэ.

Хоёр: Айл өрх бүрийн амьжиргааг дэмжихэд “хашаандаа сайхан амьдаръя” төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, өрх бүр үйлдвэрлэгч байж орон нутгийн хэрэгцээний эрүүл аюулгүй, чанартай хүнсийг сумаасаа, хашаанаасаа бэлтгэхэд анхаарна.

- 2.1. “Хашаандаа сайхан амьдаръя” аяныг үргэлжлүүлэн иргэдэд өөрсдийнх нь нөөц бололцоо, санал санаачилгад тулгуурлан явуулж, иргэдийн идэвхийг дээшлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 2.2. Сумын цагдаагийн тасаг болон холбогдох байгууллагуудтай хамтран орон нутгийн шаардлагатай газруудад хурд сааруулагч хийх ажлыг эхлүүлнэ.
- 2.3. Сумын эзэнтэй нохдыг бүртгэлжүүлж, бүртгэлгүй нохдыг устгах ажлыг багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулна.
- 2.4. Бар, цэнгээний газар болон РС тоглоомын газруудад тавих хяналтыг сайжруулж, насанд хүрээгүй хүүхдүүдийг оройн 22 цагаас хойш эцэг эхийн хараа хяналтгүй, гадуур тэнүүлэхгүй байх асуудлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.
- 2.5. “Архигүй сум” хөтөлбөр боловсруулж амжилттай ажиллаж байгаа аймаг, сумдаас туршлага судлан өөрийн сумандаа нэвтрүүлэх боломж, нөхцөлийг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.6. “Хөршийн холбоо”-г сайжруулж, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Гурав: Хувь хүний хөгжлийг дэмжихэд сумандаа эрүүл энх спортлог, амар амгалан амьдралын хэв маягийг эрхэмлэж эрүүл аюулгүй амьдрах бололцоог хангана.



- 3.1. Хүн амд эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлын чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамирыг дэмжсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран насны ангиллаар зохион байгуулна.
- 3.2. Ард иргэдийн эрүүл аж төрөх нөхцөлийг хангах зорилгоор сумын иргэдийн дунд "Спортын өдөр"-ийг холбогдох байгууллагуудтай хамтран жил бүр зохион байгуулна.
- 3.3. Сумын эрүүл мэндийн төвтэй хамтарч иргэдийг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 3.4. Сумын ахмадын хорооны үйл ажиллагааг өргөжүүлж, тэднийг урамшуулж, нийт ахмадуудынхаа урлаг, спортыг дэмжсэн олон талт үйл ажиллагаа явуулахад нь дэмжиж ажиллана.
- 3.5. Залуу, өсвөр үеийнхэнд архи, тамхины хор уршиг, муу зуршлаас хол байлгах талаарх сургалт сурталчилгааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 3.6. Суманд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах замаар тохижилт үйлчилгээ, хогны асуудлыг шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.
- 3.7. Гэр хорооллын айлуудыг төвлөрсөн халаалтад холбох боломж, нөхцөлийг судалж шийдвэрлэх дээд шатны байгууллагад уламжилна.

Бие даан нэр дэвшигч

Д.Эрдэнэцэцэг

2020 оны 07-р сарын 24